



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021.03.09 № 05/2618
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Цахим хөгжлийн газрын Салбар хоорондын зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Мөнхжаргалын Эрдэнэжаргал, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтний албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Элбэгбаянгийн Норзимаа нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч М.Эрдэнэжаргал нь Цахим хөгжлийн газрын Салбар хоорондын зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан "төрийн албаны богино дунд хугацааны сургалтад хамрагдсан байх" гэсэн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаагүй, төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдээгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-т "энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх", 43.6-д "Энэ хуульд заасан журмыг зөрчиж төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно" гэж заасан эрх зүйн зохицуулалттай.

Мөн нэр дэвшигч Э.Норзимаа нь Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан " төрийн албаны богино дунд хугацааны сургалтанд хамрагдаж төгссөн байх" гэсэн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг тус тус хангаагүй, төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдээгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т "төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас", 27.1.3-т "төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 27.1.2-т заасны дагуу нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс", 27.1.4-т "энэ хуулийн 27.1.3-т заасны дагуу нөхөх боломжгүй бол нээлттэй сонгон шалгаруулалт зарлах" гэж заасан эрх зүйн зохицуулалттай.

Түүнчлэн нэр дэвшигч Э.Норзимаа нь гадаад, дотоод худалдаа, мод суулгах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "Моннэп" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар, мөн нэр

0006004

дэвшигч М.Эрдэнэжаргал нь худалдааны зуучлал, гадаад худалдаа, онлайн худалдаа, компьютерын программ хангамжийн үйл ажиллагаа, техник хангамжийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Дижитал вишн” ХХК-ийн, гадаад худалдаа реклам чимэглэл, худалдааны зуучлал, программ хангамжийн үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Биз-Онлайн” ХХК-ийн, гадаад худалдаа, худалдааны зуучлал, программ хангамжийн үйлчилгээ, зар сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Дижитал-Идея” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар тус тус бүртгэлтэй байх тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт, хориглолтыг хэрэгжүүлж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Хашбаатар* Х.ХАШБААТАР

